

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/39/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: denechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.22 № 50

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сүүлийн гурван жил тасарсан татварын орлого үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, газрын төлбөр, хог хаягдал хураамжийн орлогыг тайлант онд 104.0-109.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд урсгал санхүүжилт 588,943.3 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн зардал нэмэгдсэнтэй холбоотой.

Бусад асуудлын хэсэг

Татварын хэлтэс нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээ 3 зорилт 47 арга хэмжээ 97.6 хувиар үнэлсэн байна. Тайланг Татварын ерөнхий газар, аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн одоогоор дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотроод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	157,619.2	164,121.90
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	640,550.40	604,467.50
Нийт хөрөнгийн дүн	798,169.50	768,589.40
Нийт өр төлбөрийн дүн		
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	798,169.50	768,589.40
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	798,169.50	768,589.40
Үйл ажиллагааны орлогын дүн	931,547.60	1,593,516.90
Үйл ажиллагааны зардлын дүн	1,024,771.60	1,623,096.90
Үйл ажиллагааны үр дүн	(43,224.00)	(29,580.00)
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	(43,224.00)	(29,580.00)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	798,169.50	768,319.40
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	841,393.50	798,169.50
Тайлант оны үр дүн		
Эцсийн үлдэгдэл		
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	958,906.80	1,583,662.60
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	958,906.80	1,568,837.90
Үйл ажиллагааны ЦМГ	-	14,824.70
Хөрөнгө оруулалтын ЦМГ	49,611.60	1,568,658.80
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,492.20	22,787.50
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,787.50	34,013.10
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,525,657.40	1,516,314.30
Урсгал зардал	1,525,657.40	1,516,314.30
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,525,657.40	1,516,314.30
Улсын төсвөөс санхүүжих	1,525,657.40	1,516,314.30
Орон нутгийн төсвөөс санхүүжих		

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 7,581.4 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг аудитын явцад залруулж, Аудитаар 7,581.4 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

ГАА-2024/39/НА-СТА-ТШЗ

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн үр дүнгийн тайланд нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг 5.298.8 мянган төгрөгөөр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 382.8 мянган төгрөгийг зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.
- **Хууль тогтоомжтой холбоотой:** Бэлтгэн нийдүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд дутуу шивсэн 1,900.0 мянган төгрөгийн гүйлгээг нөхөн тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 13,545.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 13,545.6 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

5.1 Албан шаардлага

1. Түлээ нүүрсний хөнгөлөлтөөс нийгмийн даатгал шимтгэл 216.0 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татвар 79.6 мянган төгрөгийг суутгаж тооцоогүй, 900.0 мянган төгрөгийг татвар, нийгмийн даатгалын хэлтэст тайлагнаагүй нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т/Ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал/, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.5-т/шууд бус орлого/, 11 дүгээр зүйлийн 11.1-т/Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтны албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараах бараа, ажил, үйлчилгээний орлогыг шууд бус орлогод хамруулна/, 1.1.2-т /орон сууцны ашиглалтын болон түрээсийн зардлын төлбөр, байрын хөлс, түлшний зардлын төлбөр/" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн тайлан гаргах албан шаардлага хүргүүлдсэн.

3. Ахмадын хорооны журамд заасны дагуу хүсэлт, нотлох баримт үндэслээгүй 12,350.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Ахмадын сан байгуулах ажиллуулах журам 3 дугаар зүйлийн 3.4-т /Сангаас дэмжлэг, тусламж авахыг хүссэн ахмад настан оршин суугаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолт болон бусад шаардлагатай холбогдох баримт бичгийг бүрдүүлэн байгууллагын дэргэдэх ахмадын хороо, зөвлөлд хүсэлт гаргана/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно". 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил,

ГАА-2024/39/НА-СТА-ТШЗ

Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Ахмадын сангийн журмыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Татварын хэлтэс	Санхүүгийн үр дүнгийн тайланд нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг 5,298.8 мянган төгрөгөөр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 382.8 мянган төгрөгийг зөрүүтэй тайлагнасан байна. Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд дутуу шивсэн 1,900.0 мянган төгрөгийн гүйлгээг нөхөн тайлагнасан	1	5,681.6	-	-	1	5,681.6	1	5,681.6	-	-	-	-
		1	1,900.0	1	1,900.0	1	1,900.0	1	1,900.0	-	-	-	-
Дүн		2	7,581.6	1	1,900.0	2	7,581.6	2	7,581.6	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс:		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
								Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Говь-Алтай аймгийн Татварын хэлтэс	Түлээ нүүрсний хөнгөлөлтөөс нийгмийн даатгал шимтгэл 216.0 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татвар 79.6 мянган төгрөгийг суутгаж тооцрогүй, 900.0 мянган төгрөгийг татвар, нийгмийн даатгалын хэлтэст тайлагнаагүй Ахмадын хорооны журамд заасны дагуу хүсэлт, нотлох баримт үндэслэлгүй 12,350.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.	1	1,195.6	-	-	1	1,195.6	-	-	-	-
		1	12,350.0	-	-	1	12,350.0	-	-	-	-
Говь-Алтай аймгийн Татварын хэлтэс		2	13,545.6	-	-	2	13,545.6	-	-	-	-
Нийт		2	13,545.6	-	-	2	13,545.6	-	-	-	-

6.36.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:		
		Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

ГАА-2024/39/НА-СТА-ТШЗ

Говь-Алтай аймгийн Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1	2	3	4	Тоо 5	Дүн 6	Тоо 7	Дүн 8	Тоо 9	Дүн 10
Говь-Алтай аймгийн Татварын хэлтэс	Шилэн дансанд байршуулах 5 саяас дээш 836,458.0 мянган төгрөгийн 8 гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн	1	-	-	-	1	-	-	-
	дүн	1	-	-	-	1	-	-	-